



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/364

Мандалговь

Эмчилгээний ор дэлгэн ажиллуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.5, 10.4.10 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 115, 118 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар авсан иргэдийн тоо нэмэгдэж, эмчилгээний орны тоо хүрэлцэхгүй болсон тул аймгийн төв болон бусад сумдад эмчилгээний 770 орыг хавсралтаар баталж, дэлгэн ажиллуулахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт даалгасугай.
2. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), халдвар хамгааллын дэглэмийг хангуулж хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), эмнэлгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), сумдын Онцгой Комиссын дарга нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/294 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210147

Аймгийн Засаг даргын 2021 оны  
 04 дүгээр сарын 29-ны өдрийн  
 1/34 дугаар захирамжийн хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ТЭЙ ИРГЭНД ЭМНЭЛГИЙН  
 ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ТҮР ОРНЫ ТОО

№	Эмнэлэг, эрүүл мэндийн төвийн нэр	Батлагдсан орны тоо	Дэлгэх орны тоо	Эмнэлэг дэлгэх байр
1	Нэгдсэн эмнэлэг	179	50	Нэгдсэн эмнэлгийн халдварт, сүрьеэгийн тасаг
			100	Амбулаторийн хуучин байр
2	Адаацаг	10	75	Амбулаторийн хуучин байр, эмийн сан
3	Баянжаргалан	6	30	Эмнэлгийн байр
4	Говь-Угтаал	13	30	Эмнэлгийн байр
5	Гурвансайхан	10	42	Эмнэлгийн байр
6	Дэрэн	10	70	Эмнэлгийн байр
7	Дэлгэрхангай	11	41	Эмнэлгийн хуучин байр
8	Дэлгэрцогт	7	60	Эмнэлгийн шинэ, хуучин байр
9	Луус	9	55	Эмнэлгийн байр, Соёлын төв
10	Өлзийт	8	40	Эмнэлгийн байр, Зочид буудал
11	Өндөршил	8	30	Эмнэлгийн байр, Зочид буудал
12	Сайхан-Овоо	10	35	Эмнэлгийн байр
13	Хулд	10	32	Эмнэлгийн хуучин байр
14	Цагаандэлгэр	9	30	Эмнэлгийн шинэ, хуучин байр
15	Эрдэнэдалай	19	50	Эмнэлгийн шинэ байр
<b>Бүгд</b>		<b>319</b>	<b>770</b>	